



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatrural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024/11/30 № 93.

Г Асуулга тавих тухай

"Түгжрэлийн бодит өртөг өнгөрсөн 10 жилийн дүнгээр 11.8 их наяд төгрөгт хүрч, ингээнээр бүтээж буй баялагийнхаа 8%-ийг алдаж байгаа, хэрэв энэ хэвээр үргэлжилсээр байвал 2024 он гэхэд түгжрэлийн алдагдсан боломжийн өртөг 24.3 их наяд төгрөгт хүрэхээр байна" гэсэн судалгааг таны ахалж буй Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, автозамын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны хуралд танилцуулжээ.

Иргэдийн 76 хувь нь нэн тэргүүнд шийдэх асуудлаар нэрлэж буй түгжрэлийн асуудлаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай гэж үзэж байна.


Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Түгжрэлийг бууруулах чиглэлээр өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлууд, тэдгээрийн үр дунгийн талаар;
2. Түгжрэлийн өвөөгийн нөхцөл байдал, түүний улмаас үүсч буй хохирол, алдагдсан боломжуудын талаар;
3. Түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, шийдэл болон хийхээр төлөвлөсөн ажлуудын талаар;

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2021000201